



ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
АУДИТЫН АЖИЛ
“СОР” ХК-ИЙН**

2022 оны 12 сарын 31-ний өдрийн санхүүгийн дуусвар тайлан

УЛААНБААТАР ХОТ

2023 он



ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Төмөрчний гудамж, Их найман шарга 10 давхар,
Утас: 9908-5151, 9199-1462, Факс: (976-11) 32-52-62,
E-mail: byambaahunnu@yahoo.com, http://www.dumaudit.mn

2023.03.27 № 22
танай _____-ны № _____-т

“СОР” ХК-ИЙН ТУЗ ИЙН ДАРГА
И.ДАРИЙМАА БОЛОН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ НАРТ

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Хүлээн авах хаяг: Монгол Улс, Хан-Уул дүүрэг 2-р хороо

Үйлдвэрчний гудамж, Өөрийн байр

Санхүүгийн Тайлангийн Аудитын Талаарх Тайлан

Дүгнэлт

Бид 2022 оны 12 сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн Сор ХК-ний санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар Сор ХК -ний 2022 оны 12 сарын 31-ээрх санхүүгийн байдал, тухайн жилийн орлогын дэлгэрэнгүй ба мөнгөн гүйлгээ, өмч өөрчлөлтийн тайлангууд нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Сангийн яамнаас батлан гаргасан заавар журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу Компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

Бусад Мэдээлэл

Энэхүү компани нь бусад мэдээлэл буюу үйл ажиллагааны жилийн тайлан бэлтгэдэггүй. Бидний санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлээгүй. Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа

эсэхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн Тайланд хүлээх Үүрэг Хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай байлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ. Аудитын явцад бидэнд танилцуулаагүй баримт материалаас үүдэх эрсдлийг компанийн хариуцлага гэдгийг удирдлагад сануулсан болно.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээн Аудиторын Үүрэг Хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайлан бэлтгэх явдал юм.

Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу тайлагнал нь залилан эсвэл алдаанаас шалтгаалан үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

Бид засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй аудитын хамрах цар хүрээ, цаг хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар компаниас ирүүлсэн баримт материалын хүрээнд илэрсэн дутагдал,

зөрчлийн талаарх асуудлыг зөвлөмжөөр удирдлагад танилцуулан хүргүүлсэн болно.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү аудиторын тайланг Компанийн тухай хуулийн 94.1, 95.1 дүгээр зүйлүүдэд заасны дагуу компанийн удирдлага, хувьцаа эзэмшигчдэд зориулан бэлтгэсэн. Бид уг тайлангийн агуулгын хүрээнд аливаа нэг гуравдагч этгээдийн өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.



ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК
УЛААНБААТАР ХОТ ЧД 2 ХОРОО
БАКУЛА РИНБҮҮЧИЙН ГУДАМЖ
ОРШИЛ 2 ТӨВ 5 ДАВХАРТ

Огноо: 2023.03.27

КОМПАНИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

“Сор ” ХК (цаашид “компани” гэх) нь анх үслэг эдлэлийн үйлдвэрлэл, борлуулалтын чиглэлээр үүсгэн байгуулагдсан боловч өнөөдрийн байдлаар 4878 м2 өөрийн байрын түрээсийн үйл ажиллагаа эрхэлж байна. 891388 ширхэг хувьцааг 1682 Хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж байна. ТУЗ 9 гишүүнтэй ба даргаар Ишхүүгийн Дариймаа ажиллаж байна.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН БЭЛТГЭХ ҮНДЭСЛЭЛ

Тус компани нь Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 361 дугаар “Маягт заавар батлах тухай ” тушаалын Аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар” 1 дүгээр, “Санхүүгийн тайлангийн А маягт”-ыг 2 дугаар хавсралтуудыг үндэслэн бэлтгэсэн.

Компанийн хувьцаа эзэмшигчид компанийн өр төлбөрийг барагдуулах хангалттай мөнгөн хөрөнгөтэй байлгахыг хүлээн зөвшөөрдөг учраас компани санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэсэн. 2022 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлангаар компани 48,181.6 мянган төгрөгийн алдагдалтай ажиллаж, компанийн нийт хөрөнгө /1,005,549.5 мянган төгрөг/ нийт өр /633,748.4 мянган төгрөг/төлбөрөөсөө 371,801.1 мянган төгрөгөөр өөрийн хөрөнгө их байна. Үүнээс харахад компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн, тогтвортой явуулах боломж өмнөх жилүүдтэй харьцуулахад алдагдал буурч байна.

Стандартын баримтлал ба хэрэгжүүлэлт

Энэхүү санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид “СТОУС” гэх), Олон улсын санхүүгийн тайлагналын стандартын Тайлбарын байнгын хорооноос баталсан тайлбар болон Монгол Улсын зохих хууль, тогтоомжийн дагуу бэлтгэсэн.

01. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ОНЦЛОХ БОДЛОГУУД

Гадаад валютын хөрвүүлэлт

Санхүүгийн тайланг төгрөгөөр илэрхийлсэн бөгөөд компани үйл ажиллагаагаа явуулдаг албан ёсны мөнгөн тэмдэгт нь Монгол улсын мөнгөн тэмдэгт төгрөг юм. Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээг тухайн валютаар болон гүйлгээ хийгдэх үеийн Монгол банкнаас зарласан албан ханшаар төгрөгт шилжүүлэн, төгрөг/валютаар давхар бүртгэдэг. Гадаад валютаарх мөнгөн хөрөнгө, тооцооны дансыг балансын дуусгавар болсон өдрийн албан ханшаар төгрөгт шилжүүлэн бүртгэсэн. Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээнээс үүссэн зөрүүг орлогын

тайланд тусгагддаг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийг түүхэн өртгөөр нь тооцож, тухайн ажил гүйлгээ анх гарсан өдрийн ханшаар хөрвүүлэн бүртгэдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийг нэрлэсэн үнээр нь бүртгэдэг бөгөөд нэрлэсэн үнийг тогтоосон өдрийн ханшаар хөрвүүлэн балансад тусгадаг.

Холбоотой талууд

Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд холбоотой талууд оршин байдаг ч хяналтын эрхгүй, санхүүгийн болон үйл ажиллагааны бодлогын шийдвэрт оролцдог.

Зээлийн хүү

Зээлийн хүүг анх бүртгэхдээ нэрлэсэн үнээр нь бүртгэдэг. Дараагийн тайлант хугацаа бүрт анх бүртгэсэн нэрлэсэн үнэ болон зээлийн хүүг төлсөн үеийн үнийн зөрүүгээр хорогдуулж зээлийн хугацаанд үүссэн олз, гарзыг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хүүгийн аргыг ашиглан орлого үр дүнгийн тайланд ашиг, алдагдлаар тусгана.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулиар доорх заалтуудыг мөрдлөг болгон ажиллах.

14.1.Энэ хуулийн 8.1.1-д заасан үндсэн болон туслах үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхлэх, түүнчлэн эд хөрөнгө худалдан авах зорилгоор авсан зээлийн хүүгийн төлбөрийг албан татвар ногдох орлогоос хасаж тооцно.

14.2.Албан татвар төлөгч аж ахуйн нэгжийг хяналтандаа байлгадаг Монгол Улсад байнга оршин суугч хувь хүнээс авсан зээлийн хүүгийн төлбөрийг тухайн албан татвар төлөгчийн албан татвар ногдох орлогоос хасаж тооцохгүй бөгөөд энэ зардлыг зээл олгосон тухайн хувь хүний ногдол ашигт тооцож албан татвар ногдуулна.

Санхүүгийн тайлан тодруулга, НББ-ын программ хангамжийн талаар.

1. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь касс дахь бэлэн мөнгө ба банкин дахь харилцах данснуудаас бүрддэг. Мөнгөн хөрөнгийг банканд байлгах нь ямар нэг эрсдэл агуулахгүй. Харин мөнгөн хөрөнгө нь бэлнээр хадгалах гүйлгээ хийх нь эрсдэлийг дагуулж байдгийг анхаарах хэрэгтэй. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг нэрлэсэн үнээр нь бүртгэдэг. Гадаад валютаарх мөнгөн хөрөнгийг Монгол банкнаас зарласан албан ханшаар төгрөгт шилжүүлж бүртгэдэг.

Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө

№	Үзүүлэлт	/Мянган төгрөг/	
		2022.12.31	2021.12.31
1	Касс дахь мөнгө	13,031.7	5,696.1
2	Банкин дахь мөнгө	640.2	184.2
3	Мөнгөтэй адилтгах хөрөнгө	0.0	0.0
4	Нийт дүн	13,671.9	5,880.3

Бэлэн мөнгөний тооллогын бүртгэл нотломж, үлдэгдлийн баталгаажилт хийгээгүй байна.

Харилцах дансдын эхний болон эцсийн үлдэгдэл баталгаажилт хангаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн доорх заалтуудыг мөрдөн ажиллахыг сануулж байна. Үүнд:

13.5. Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна; 13.6. Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна; 13.7. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.

Дансны авлагууд

Авлага нь үүссэн тухайн үеийн нэхэмжлэгдэх дүнгээр бүртгэгдсэн. Авлагын хувьд насжилт, цуглуулагдах магадлалыг үнэлэн нөөцийн сан байгуулдаггүй. Дансны авлага тайлант жилд үлдэгдэлгүй байна

Татварын авлага

№	Үзүүлэлт	/Мянган төгрөг/	
		2022.12.31	2021.12.31
1	ААНОАТ-ын авлага	0.0	0.0
2	НӨАТ-ын авлага	48,280.0	36,355.5
3	НДШ-ийн авлага	0.0	0.0
4	ХХОАТ	0.0	0.0
	Нийт дүн	48,280.0	36,355.5

Татварын тооцооллыг нарийвчлан хийгээгүй тул холбогдох татварын албатай авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулан ажиллахыг сануулж байна.

Бусад богино хугацаат авлага

/Мянган төгрөг/

№	Үзүүлэлт	2022.12.31	2021.12.31
1	Холбоотой талаас авах авлагын тайлант хугацаанд хамаарах дүн	0.0	0.0
2	Ажиллагчдаас авах авлага	0.0	0.0
3	Ноогдол ашгийн авлага	0.0	0.0
4	Хүүний авлага	0.0	0.0
4	Богино хугацаат авлагын бичиг	0.0	0.0
4	Бусад талуудаас авах авлага	56,058.9	7,438,433.1
4		0.0	0.0
4	Нийт дүн	56,058.9	7,438,433.1

Д/Д	Үзүүлэлт	2022.01.01	Нэмэгдсэн	Хасагдсан	2022.12.31
1	Блю Скай Кашемир ХХК	1,530,848.7		1,530,848.7	
2	Блю Скай Ложистик ХХК	619,371.9		619,371.9	
3	Блю Скай Майнинг	5,145,057.9		5,145,057.9	
4	Эс Жи групп	85,741.6		32,204.7	53,536.9
	Нийт дүн	7,381,020.2		7,327,483.3	53,536.9

Дээрх авлагын үлдэгдлийн хаасан тооцоог дахин хянан үзэн, баримтын баталгаажилтыг тодруулга тайлбарыг гарган өгөхийг анхааруулж байна.

Бараа материал

Бараа материалыг цэвэр боломжит үнэ цэнэ буюу цэвэр боломжит өртгөөр нь бүртгэдэг. Цэвэр боломжит үнэ цэнэ гэж бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад борлуулахаар тооцсон үнээс түүнийг иж бүрдэл болгохоор тооцсон зардал ба борлуулахад тооцсон зардлыг хассан дүн юм.

Бараа материалын үлдэгдэлгүй байна.

Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг түүний өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр тайлагнадаг ба үндсэн хөрөнгийн өртөг нь худалдан авалтын өртөг болон хөрөнгийг ашиглалтын хэвийн нөхцөлд оруулахад шууд хамаарах зардлаас бүрддэг. Үндсэн хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын аргаар тооцож, байгуулдаг бөгөөд үндсэн хөрөнгийн элэгдүүлэх хугацааг татварын зорилгоор байгуулан өртөгт шингээдэг байна.

/Мянган төгрөг/

Үзүүлэлт	Барилга байгууламж	Машин, тоног	Тээврийн хэрэгсэл	Тавилга эд хогшил	Компьютер, бусад хэрэгсэл	Бусад үндсэн хөрөнгө	Нийт дүн
Үндсэн хөрөнгө /ӨРТӨГ/	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Эхний үлдэгдэл	1,193,395.1	0.0	0.0	125.0	1,347.4	0.0	1,194,867.5
Эцсийн үлдэгдэл	1,193,395.1	0.0	0.0	125.0	1,347.4	0.0	1,194,867.5
ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ							
Эхний үлдэгдэл	276,190.8	0.0	0.0	98.9	0.0	0.0	276,289.8
Нэмэгдсэн дүн	29,834.5	0.0	0.0	3.1	0.0	0.0	29,837.6
Байгуулсан элэгдэл	29,834.5	0.0	0.0	3.1	0.0	0.0	29,837.6
Эцсийн үлдэгдэл	306,025.4	0.0	0.0	102.0	0.0	0.0	306,127.5
ДАНСНЫ ЦЭВЭР ДҮН	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Эхний үлдэгдэл	917,204.4	0.0	0.0	26.0	0.0	0.0	917,230.4
Эцсийн үлдэгдэл	887,369.6	0.0	0.0	22.9	0.0	0.0	887,392.5

Үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн эхний ба эцсийн цэвэр дүн санхүү байдлын тайлантай зөрүүтэй тайлагнасан байна.

Биет бус хөрөнгө

/Мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Компьютерийн программ хангамж	Нийт дүн
1	БИЕТ БУС ХӨРӨНГӨ /ӨРТӨГ/	0.0	0.0
1.1	Эхний үлдэгдэл	454.9	454.9
1.4	Эцсийн үлдэгдэл	454.9	454.9
2	ХУРИМТЛАГДСАН ХОРОГДОЛ	0.0	0.0
2.1	Эхний үлдэгдэл	297.3	297.3
2.2	Нэмэгдсэн дүн	11.3	11.3
2.2.1	Байгуулсан хорогдол	11.3	11.3
2.4	Эцсийн үлдэгдэл	308.6	308.6
3	ДАНСНЫ ЦЭВЭР ДҮН	0.0	0.0
3.1	Эхний үлдэгдэл	157.5	157.5
3.2	Эцсийн үлдэгдэл	146.1	146.1

Дансны өглөг

Богино хугацаат өр төлбөр нь тайлант хугацаанд үүссэн бараа, үйлчилгээний худалдан авалт, үйл ажиллагааны зардал, татвар, шимтгэл, цалинтай холбогдох өглөг бөгөөд тэдгээрийг үүссэн тухайн үеийн нэрлэсэн дүнгээр санхүүгийн тайланд тусгадаг. Өглегийн хувьд хөнгөлөлт, хасагдуулаг тооцдоггүй.

/Мянган төгрөг/

№	Үзүүлэлт	2022.12.31	2021.12.31
1	Төлөгдөх хугацаандаа байгаа	21,264.8	21,264.8
2	Хугацаа хэтэрсэн	0.0	0.0
	Нийт дүн	21,264.8	21,264.8

Татварын өр

/Мянган төгрөг/

№	Үзүүлэлт	2022.12.31	2021.12.31
1	ХХОАТ -ын өр	712.3	730.6
2	НДШ өр	-9.3	
	Нийт дүн	703.0	730.6

НДШ-ийн өглөгийг тохируулах бичилтийг хийн залруулан , тооцоог нийлэн баталг Татварын тооцооллыг нарийвчлан хийгээгүй тул холбогдох татварын албатай өгг тооцооны үлдэгдлийг баталгаажуулан ажиллахыг сануулж байна.

Бусад богино хугацаат өр төлбөр

/Мянган төгрөг/

№	Үзүүлэлт	2022.12.31	2021.12.31
1	Ноогдол ашгийн өглөг	0.0	0.0
1	Бусад богино хугацаат өр төлбөр	602,429.1	5,380,294.0
	Нийт дүн	602,429.1	5,380,294.0

Д/Д	Харилцагч	2022.01.01	Нэмэгдсэн	Хасагдсан	2022.12.31
1	Зеннор Интернейшнл Лимитид	5,380,294.0		4,777,865.0	602,429.1
	Дүн	5,380,294.0		4,777,865.0	602,429.1

Бусад өглөгийг хаасан анхан шатны баримтыг тодруулан гарган тайлбар хийж баталгаажилтыг ханган өгөх

Урт хугацаат зээл

№	Үзүүлэлт	төгрөгөөр	валютаар	төгрөгөөр	валютаар
1	Урт хугацаат зээлийн дүн	244,807.6	0.0	0.0	0.0
1.3	Дотоодын эх үүсвэрээс авсан зээл	0.0	0.0	0.0	0.0
2	Бусад урт хугацаат өр төлбөрийн дүн	0.0	0.0	0.0	0.0
2.1	(Гадаад, дотоодын зах зээлд гаргасан бонд, өрийн бичиг)	0.0	0.0	0.0	0.0

Дансны өглөгийн тооцоог байгууллага нэг бүрээр тооцоо нийлсэн актаар баталгаажуулах шаардлагатай.

Богино болон урт хугацаат зээлийн тооцоог тодруулан тайланд хугацааны төлбөрийг хугацаанд нь барагдуулан ажиллаж эрсдэлээс сэргийлэн хяналт тавьж байх.

2. Орлого хүлээн зөвшөөрөх

Орлогыг хүлээн авсан эсвэл хүлээн авахаар хүлээгдэж буй төлбөрийн бодит үнэ цэнээр бүртгэнэ. Орлогод зөвхөн тухайн бизнесийн үйл ажиллагаанаас хүлээн авсан болоод ирээдүйд хүлээн авах эдийн засгийн өгөөжийн дотогш урсгал хамаарна. Суутгасан татвар, барааны болон үйлчилгээний хураамж, нэмэгдсэн өртгийн татвар зэрэг гуравдагч талын өмнөөс цуглуулсан дүн нь аж ахуйн нэгжийн эдийн засгийн өгөөжид хамаарахгүй бөгөөд эзэмшигчдийн өмчийг нэмэгдүүлэхгүй. Иймээс эдгээрийг орлогын дүнгээс хасаж тооцдог. Компанийн хувьд орлогын хүлээн зөвшөөрөлт дараах байдалтай байна. Үүнд:

- Түрээсийн орлого

/Мянган төгрөг/

№	Үзүүлэлт	2022.12.31	2021.12.31
1	Түрээсийн орлого	71,107.2	63,257.0
2	Нийт борлуулалтын орлого	71,107.2	63,257.0

Орлогоос нэмэгдсэн өртгийн албан татварыг хассан дүнгээс худалдааны хөнгөлөлт, буцаалт зэргийг хасаж тооцдог.

- Хүүний орлого
Үр ашигт хүүгийн аргыг ашиглан хүүгийн орлогыг хүлээн зөвшөөрч аккурэл сууриар бүртгэдэг.

3. Орлогын албан татвар

Тайлант үеийн татвар гэдэгт тайлант үеийн татвар ногдуулах ашиг (алдагдал)-аас тооцсон орлогын албан татварын өглөгийн дүн болон хойшлогдсон татварын өглөг эсвэл хойшлогдсон татварын хөрөнгөөс бүрддэг. Тайлант жилийн татвар нь тухайн жилийн орлогоос хуулийн дагуу тогтоосон татварын хувиар ногдуулсан татварын өглөгийн дүн юм.

Хойшлогдсон татварын хөрөнгө болон татварын өглөг нь санхүүгийн байдлын тайлан дахь хөрөнгө, эсвэл өр төлбөрийн дансны үнэ ба татварын суурь хоёрын хоорондох зөрүүнээс үүсдэг. Түр зөрүү нь хоёр хэлбэртэй бөгөөд эдгээр нь зэрэг тодорхойлогддоггүй, аль нэг нь л байна. Үүнд:

- *татвар ногдох түр зөрүү* гэдэг нь хөрөнгө эсвэл өр төлбөрийн дансны үнийг нөхөх эсвэл барагдуулах үед ирээдүйн тайлант үеийн

татвар ногдуулах ашиг (татварын алдагдал)-ыг тодорхойлоход татвар ногдох орлогод үүсэх түр зөрүү юм.

- хасагдах түр зөрүү гэдэг нь хөрөнгө эсвэл өр төлбөрийн дансны үнийг нөхөх эсвэл барагдуулах үед ирээдүйн татвар ногдуулах ашиг (татварын алдагдал)-ыг тодорхойлоход татвар ногдох орлогоос хасагдах дүнгээс үүсэх түр зөрүү юм.

4. Эздийн өмч

№	Үзүүлэлт	Тоо ширхэг	/Мянган төгрөг/		
			2022.12.31	Тоо ширхэг	2021.12.31
1	Эхний үлдэгдэл	891,388	87,887.9	891,388	87,887.9
2	Нэмэгдсэн	0.0	0.0	0.0	0.0
3	Хасагдсан	0.0	0.0	0.0	0.0
4	Эцсийн үлдэгдэл	891,388	87,887.9	891,388	87,887.9

Тус компанийн эзэмшигчдийн өмч нь өөрийн хөрөнгө (дүрмийн сан), эздийн өмчийн бусад хэсэг, өмнөх үеийн болон тайлант хугацааны хуримтлагдсан ашиг, алдагдлаас бүрддэг.

2022 онд санхүүгийн тайлангаар компани 48,181.6 мянган төгрөгийн алдагдалтай ажиллаж байна.

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУД

"СОР" ХК

**АУДИТ ХИЙСЭН САНХҮҮ БАЙДЛЫН
ТАЙЛАН**

төгрөгөөр

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2021.12.31	2022.12.31
А	Б	1	2
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	5,880,368.16	13,671,985.61
1.1.3	Татвар,НДШ-ийн авлага	36,355,487.58	48,279,946.42
1.1.4	Бусад авлага	7,438,433,053.35	56,058,875.42
1,1,11	Эргэлтийн хөрөнгийн дүн	7,480,668,909.09	118,010,807.45
1.2.1	Үндсэн хөрөнгө	917,230,246.57	887,392,535.89
1.2.2	Биет бус хөрөнгө	157,530.56	146,156.72
1,2,10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	917,387,777.13	887,538,692.61
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	8,398,056,686.22	1,005,549,500.06
2.1.1.1	Дансны өглөг	21,264,800.00	21,264,800.00
2.1.1.4	НДШ-ийн өглөг	(12,265.92)	(9,301.38)
2.1.1.6	Хүүний өглөг	2,321,637,618.75	
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	9,351,466.39	9,351,466.39
2.1.1.9	Орлогын албан татварын өглөг	730,639.30	712,357.69
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	5,380,294,027.40	602,429,071.37
2,1,1,13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	7,733,266,285.92	633,748,394.07
2.1.2.1	Урт хугацаат зээл	244,807,610.00	
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	244,807,610.00	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	7,978,073,895.92	633,748,394.07
2.3.3	- хувьцаат	87,887,966.00	87,887,966.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг(алдагдал)	332,094,824.30	283,913,139.99
2,3,11	Эздийн өмчийн дүн	419,982,790.30	371,801,105.99
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	8,398,056,686.22	1,005,549,500.06

**АУДИТ ХИЙСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ
ТАЙЛАН**

төгрөгөөр

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Түрээсийн орлого	63,257,018.18	71,107,200.00
2	Бусад орлого	12.14	12.78
3	Ерөнхий ба удирдлагын зардал	68,633,523.87	70,650,163.40
4	Бусад зардал	60,059,878.00	48,638,733.69
5	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(65,436,371.55)	(48,181,684.31)
6	Татварын дараах ашиг (алдагдал)	(65,436,371.55)	(48,181,684.31)
7	Татварын үеийн цэвэр ашиг (алдагдал)	(65,436,371.55)	(48,181,684.31)
8	Орлогын нийт дүн	(65,436,371.55)	(48,181,684.31)

АУДИТ ХИЙСЭН ӨМЧ ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

№	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 01-р сарын 31-ний үлдэгдэл	87,887,966.00	332,094,824.30	419,982,790.30
2	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		(48,181,684.31)	(48,181,684.31)
3	2022 оны 12-р сарын 31 ний үлдэгдэл	87,887,966.00	283,913,139.99	371,801,105.99



АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

төгрөгөөр

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	100,277,848.86	175,690,806.00
	Бараа борлуулсан үйлчилгээ үзүүлсэн орлого	100,277,848.86	175,690,806.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	100,544,323.20	167,899,188.55
	Ажилчдад төлсөн	22,172,640.00	30,060,795.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн		
	Бараа материал худалдан авахад төлсөн	5,273,319.00	189,763.68
	Ашиглалтын зардалд төлсөн	24,691,701.00	101,766,887.00
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	780,000.00	
	Татварын байгууллагад төлсөн	44,738,983.20	29,897,062.87
	Бусад мөнгөн зарлага	2,887,680.00	5,984,680.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(266,474.34)	7,791,617.45
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(266,474.34)	7,791,617.45
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,146,842.50	5,880,368.16
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,880,368.16	13,671,985.61

Санхүү тайлан нь аудитын тайлангийн салшгүй хэсэг болно.

ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК

